



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/45

Рашаант сум

Мод бэлтгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт, сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны аж ахуйн тайланг ИТХ-аар хэлэлцүүлж үнэлүүлсэн ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудад сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолын дагуу мод бэлтгэх зөвшөөрөл олгосугай.

2.Батлагдсан дээд хязгаарт багтаан арчилгаа, цэвэрлэгээний огтлолт явуулах, цэвэрлэгээний ажил хийх, ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд мод бэлтгэх талбай тусгаарлалтыг харьяалсан "Дэлгэрмөрөн" сум дундын ойн ангиар хийлгэхийг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Б.Идэр)-д даалгасугай.

3.Тухайн жилийн батлагдсан хэмжээнээс илүү мод бэлтгүүлэхгүй хяналт шалгалтын ажлыг сайтар зохион байгуулан ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (М.Билэгдэмбэрэл), Ахлах байгаль хамгаалагч (Н.Отгончимэг), байгаль хамгаалагч (Э.Өлзийжаргал) нарт үүрэг болгосугай.

4.Ойн нөхөрлөл аж ахуй нэгж байгууллагын ойжуулалтын ажлыг зохион байгуулах, хүлээн авах ажлын хэсэг байгуулах, үр дүнг хагас бүтэн жилээр тайлагнах зэрэг ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Б.Идэр)-д даалгасугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

D:\nasaa bichig hereg\A-Zax.doc

6706011079